



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-12

- 1. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/* 5-12

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 04 дүгээр сарын 11-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 29 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ч.Хүрэлбаатар, Б.Энхбаяр.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам үг хэлж, хэлэлцэх асуудлын дараалалд орсон “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хойшлуулахаар тогтов. /11.35/

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг үг хэлэв.

Нэг.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, мөн яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга Т.Мөнх-Од, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч Н.Жамъянхүү, “Монголын эрх зүйн судалгаа, хөгжлийн төв” төрийн бус байгууллагын хуульч, судлаач Р.Лхагвасүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Улсын Их Хурлын гишүүний гаргасан горимын саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нар тайлбар хийв.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.2 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, уг асуудлыг хойшлуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 26 минут үргэлжилж, 18 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 88.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
11 цаг 29 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Гишүүд өнөөдөр ирц бүрэн ирж байгаа юм байна.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 77.8 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд.

Хоёр.“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн хоёр асуудал хэлэлцэх хуваарьтай байна.

“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төслийн ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн

Ч.Ундрам төслийнхөө талаар мэдээлэл хэлэх үү.

Ч.Ундрам гишүүний микрофоныг нээе.

Ч.Ундрам: Энэ хоёр дахь асуудал буюу “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн дэд хэсгийн тодорхой хүмүүс өвчтэй байсан учраас хуралдаж амжаагүй.

Тийм учраас нэг долоо хоног хойшлуулж өгөөч ээ гэсэн саналтай байгаа. Энэ асуудлыг.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг хуралдаж амжаагүй байгаа учраас энэ тогтоолын төслийг хэлэлцэх асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлуудаас ингээд хасчихъя.

Тэгээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Х.Ганхуяг гишүүн саналаа хэлье. Х.Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Сайн байна уу. Энэ өдрийн мэндийг хүргэе.

Өчигдөр бүлгийн хурал дээр нэг санал гаргасан байгаа юм.

Тэгээд бид одоо энэ төр ер нь эдийн засагт хэрхэн яаж оролцох талаар бид Зөвшөөрлийн хууль амжилттай батлуулаад одоо ингээд хэрэгжээд эхэлсэн байгаа. Зөвшөөрлийн хуулийн хэрэгжилттэй холбоотой санал, дүгнэлтийг нь 5 сард танилцуулна. Байнгын хороон дээр.

Гэхдээ энэ асуудал бол зөвхөн Зөвшөөрлийн хуулиас гадна яг энэ эдийн засагт оролцож байгаа төрийн оролцоо

асар өндөр байгаа хэвээр л байна. Одоо өнгөрсөн жилийн хугацаанд төрийн өмчийн компаниудын тухай асуудал нэлээн сөхөгдлөө. Одоо энэ төрийн өмчийн компаниудын хууль Улсын Их Хуралд өргөн баригдаад ажлын хэсэг байгуулагдаад явж байна.

Түүнээс гадна яг эдийн засгийн болон бусад давуу байдал олгодог дахиад нэг өөр субъект байдаг. Тэр нь Засгийн газрын тусгай зориулалттай сангууд байгаа.

Тэгээд яах вэ, бид аль нэг салбарын хөгжлийг бодоод ингээд сангууд байгуулаад явчихдаг. Тэгээд тэр нь яах вэ, зорилго байхгүй, хэрэгжих хугацаа байхгүй, зорилгоо хэрэгжээд явж байгаа эсэх дээр дүгнэлт байхгүй. Зүгээр жилд нэг аудитын тайлангаар хэрхэн яаж зарцуулагдсан гэдэг талаар нэг тойм байдлаар мэдээ авахаас өөрөөр ингээд мэдээлэл авахгүй байгаад байна.

23 тусгай зориулалттай сан байна. Одоо ингээд Боловсролын зээлийн

Нэг.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулна.

Х.Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

сангийн асуудал нэлээн сөхөгдөж яригдаж байна. Өөрсдөө сурдаг. Дараа нь хүүхдүүдээ сургадаг.

Тариалан эрхлэлтийг дэмжих сан гээд. Нэг компани 20 өөрийн хамаарал бүхий этгээдээр зээл авчихсан. 50 хувийг нь. Гэх мэтчилэн асуудлууд байгаад байгаа болохоор энэ сангуудтай холбоотойгоор ажлын хэсэг байгуулах, шалгах, санал, дүгнэлт гаргах ийм ажлын хэсэг байгуулах тал дээр гишүүдийг дэмжиж өгөөч ээ гэдэг санал гаргах гэсэн юм. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Х.Ганхуяг гишүүний гаргасан саналыг ойлголоо.

Ингээд дараагийн долоо хоногийн Байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулах тогтоолын төсөл цөмөөрөө хэлэлцье.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орё.

Х.Ганхуяг: Байгаа хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Та бүхэнд танилцуулъя.

Засгийн газраас Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт 12 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн.

Төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг нэгдсэн чуулганы 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр хийж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Х.Булгантуяа, Ш.Адъяа, Т.Доржханд, М.Оюунчимэг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан.

Ажлын хэсэг нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам болон салбарын хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулж ажиллалаа.

Аялал жуулчлалын тухай хуулийн төслийн талаарх **D-Parliamen.mn** системээр 158 санал ирсэн.

Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас салбарын компани, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй хамтран Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 85 зарчмын зөрүүтэй санал, хамт өргөн мэдүүлсэн 12 хуулийн төсөлтэй холбогдуулан 14 зарчмын зөрүүтэй санал бэлтгэснийг ажлын дэд хэсэг дээр хэлэлцсэн болно.

Мөн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Аялал жуулчлалын тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж салбарын компаниуд, төрийн бус байгууллагын төлөөллийн саналыг авсан болно.

Ажлын хэсэг Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боломжит хүрээнд багцлан 72 зарчмын зөрүүтэй санал, 3 найруулгын санал, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан 24 зарчмын зөрүүтэй санал, нийт 96 зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэн Та бүхэнд тараасан болно.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллын агуулгыг томъёолон тоймлон Та бүхэнд танилцуулж байна. Үүнд:

Нэг.Нэр томъёоны хэсэгт Дэлхийн аялал жуулчлалын байгууллага болон салбарын төлөөллүүдийн гаргасан саналын хүрээнд зарим өөрчлөлтийг тусгалаа.

Хоёр.Тур оператор нь тусгай зөвшөөрөл шаардахгүйгээр аялал жуулчлалын мэргэжлийн холбоо буюу нийт эрх зүйн хуулийн этгээд бүртгүүлж, үйл ажиллагаа явуулахаар тусгалаа.

Гурав.Аялал жуулчлалыг хөгжүүлэх санг шаардлагагүй гэж үзэж хасах санал бэлтгэлээ.

Дөрөв.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсийн талаар зохицуулалтыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулах болон бусад өөрчлөлтийг тусгалаа.

Тав.Отголох цэгтэй холбоотой зохицуулалтад зарим өөрчлөлт орууллаа.

Түүнчлэн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд хуулийн зүйл, заалт хоорондын нийцлийг хангах болон зарим зарчмын өөрчлөлтийг тусгасан санал бэлтгэсэн болно.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхэн хүсэж байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийг танилцуулъя.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Төгсгэрэлийн Мөнх-Од Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Сүхбаатарын Цогтгэрэл Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч, Ринченпүрэвийн Лхагвабаяр Монголын “Эрх зүйн судалгаа хөгжлийн төв” төрийн бус байгууллагын хуульч, судлаач.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Н.Ганибал гишүүнээр тасаллаа.

Б.Жавхлан гишүүний микрофоныг нээе.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, гишүүдийн өглөөний мэндийг хүргэе.

Аялал жуулчлалын тухай хууль маань Засгийн газраас өргөн барьсан хууль.

Welcome to Mongolia 2023, 2024 гээд дунд хугацааны эдийн засгийг дэмжих томоохон хөтөлбөр. Аялал жуулчлалын салбарыг томоохон эдийн

засгийн үйлдвэрлэлийн салбар болгох зорилготой хууль байгаа.

Нэлээдгүй реформ, шинэчлэлүүдийг чадлаараа хийсэн хуулийг Засгийн газраас өргөн барьсан юм.

Ажлын хэсгийн ахалж байгаа Х.Ганхуяг гишүүний хувьд бид үзэл баримтлалыг ойлгож дэмжиж байгаа. Мэдээж энэ томоохон хөтөлбөрийн хүрээнд хийвэл хийсэн шиг дорвитой реформ хийчихье гэж байх шиг байгаа. Үүнийг үзэл баримтлалын хувьд дэмжинэ.

Харин энэ дээр татвартай холбоотой асуудлууд байгаа юм.

Засгийн газар өөрсдөө бид үүнийг өргөн барихдаа татварын суурь хуулиудтай нийцүүлээд дэмжиж болох зүйлүүдээ оруулаад явуулсан байгаа.

Тэгээд татварын хуулиараа. Одоо зөвхөн татварын хуулиар шүү. Татвартай холбоотой аливаа хуульд орох өөрчлөлтийг зөвхөн Засгийн газар санаачилж, Засгийн газраас санал авуулж ингэж хэлэлцдэг ийм хуультай.

Тэгэхээр өргөн барьсан хувилбар дээр НӨАТ-тай холбоотой ямар ч заалт байхгүй. Зөвхөн татвартай холбоотой. Одоо бидний энгийн ойлголтоор **tax free** буюу гаднын жуулчдад буцаан олголтын зохицуулалтыг цоо шинээр хийж өгсөн ийм харилцааг зохицуулсан заалтууд орсон байсан.

Түүнээс биш илүүтэйгээр одоо энд саналын зөрүүтэй томъёологдсон байгаа энэ НӨАТ-тай холбоотой заалтуудыг огт оруулаагүй. Засгийн газраас.

Өөрөөр хэлбэл татвартай холбоотой асуудлыг хөндөх субъект нь өөрсдөө үүнийг оруулаагүй гэсэн үг.

Тэгэхээр үүнийг хэлэлцэж, саналын томьёолол гэж хураах нь дэгийн тухай хуулиараа зөрчигдөнө. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, өчигдөр ажлын хэсгийн хурал. Би өмнөх ажлын хэсгийн хурлууд дээр нь байсангүй. Зүгээр өчигдөр ажлын хэсгийн хурал гээд би бас саналаа хэлэх гээд ирсэн. Ажлын хэсгийн гишүүдээс нэг л гишүүн байсан.

Тэгэхээр саналын томьёолол гаргаж, ажлын хэсэг дээр саналын зөрүүтэй санал хураалгасан асуудлуудаа л зөвхөн Байнгын хороон дээр оруулж ирж санал хураалгах ёстой шүү дээ.

Тэгэхээр энэ дэгээ барьж явах нь зөв болов уу л гэж саналтай байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн ахлагч Х.Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Нэгдүгээрт, НӨАТ-ын буцаалттай холбоотой асуудал энэ хуульд хөндөгдөж байгаа.

Одоо **tax free** гээд гадаадын жуулчид манайхаас бараа, бүтээгдэхүүн худалдаж авбал НӨАТ-ын буцаалт хийх асуудал энэ хуулиар хөндөгдсөн байгаа.

Хоёрдугаарт, Засгийн газраас орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээтэй холбоотой НӨАТ-ыг тэглэх асуудал орж ирсэн. Дотоодын тээвэр. Тийм.

Тэгээд бид аялал жуулчлалын хэлэлцүүлэг хийх шатанд энэ санал орж ирсэн. Ажлын дэд хэсгээс орж ирсэн. Засгийн газар луу санал авхуулахаар бид өнгөрсөн долоо хоногийн нэг дэх өдөр бичиг явсан. Тав дахийн дотор хариу өгөөч ээ гээд.

Гэхдээ түүн дээр хоёрхон яамнаас надад хариу ирсэн. Засгийн газраас нэгдсэн байдлаар надад хариу ирээгүй. Зам тээвэр, Аялал жуулчлалын яамнаас ирсэн. Танаас өчигдөр ирсэн.

Тэгэхээр яах вэ, энэ дээр бид нэг зарчмын зөрүүтэй ганц асуудал байгаа юм. Энэ хууль дээр **“аялал жуулчлалыг хөгжүүлэх сан”** гэдэг нэр томьёо орж ирсэн байгаа. Тэгээд одоо ингээд салбарыг хөгжүүлнэ ээ гээд.

Энэ хөгжүүлнэ гэдэг маань татвар төлөгчдийн мөнгөөр л тийшээ зарцуулалт хийнэ ээ л гэсэн үг.

Тэгээд бид татвар төлөгчдийн мөнгийг нь аваад л, дахиад л өөр тийшээ зарцуулалт хийдэг байхаасаа илүү татварын бодлогоороо аль нэг салбараа дэмжээд явдаг баймаар байна.

Аялал жуулчлал гэдэг маань энэ бүс нутагтаа бид өрсөлдөх гээд байгаа байхгүй юу. Энэ бүс нутагтаа. Бид одоо энэ Өвөр Монголтой өрсөлдөнө. Тэр Харбинтай өрсөлдөнө, Манжууртай өрсөлдөнө.

Тэгээд дотоодын нислэг маань манайх одоо Баян-Өлгий рүү нисэхэд 1 сая 800 мянган төгрөг байна шүү дээ. Үгүй ээ, ядаж тэр 10 хувийн НӨАТ-ыг нь бид хөнгөлөөд өгчихмөөр л байна шүү дээ. Тэр нь жилийн 4 тэрбум төгрөгийн л асуудал байгаа байхгүй юу.

НӨАТ-тай холбоотой ерөөсөө хоёрхон л асуудал байгаа. Энэ дотоодын нислэгтэй холбоотой НӨАТ-ын асуудал байгаа.

Мөн одоо тэр зочид буудал НӨАТ-ын буцаалт хийдэг болгох гэсэн ийм л хоёр асуудал байгаа.

Энэ дээр Та бүхэн маань, гишүүд маань санал хураалтаар л асуудлаа шийдчихвэл надад зүгээр юм болов уу гэж байна.

Энэ дэг зөрчсөн асуудал бол байхгүй. Засгийн газарт бид саналаа явуулсан. Нэг дэх өдөр бид явуулсан шүү. Б.Жавхлан сайд аа. Дэг бол зөрчөөгүй.

Тэгээд бид цаашдаа ер нь аль нэг салбарыг дэмжихдээ татварын бодлогоороо дэмжих юм уу, аль эсвэл дандаа ингээд сан байгуулаад, тэгээд хэн нэгэнд нь давуу байдал бий болгоод ингээд яваад байх юм уу гэдэг л. Одоо өнөөдөр шийдэх л асуудлуудын нэг болчхоод байгаа байхгүй юу.

Яагаад тэр салбарыг нь бид татварын бодлогоороо дэмжиж болохгүй байгаа юм бэ л гэдэг асуудал байхгүй юу.

Ц.Цэрэнпунцаг: Б.Жавхлан гишүүнд тодруулж 1 минут өгье.

Б.Жавхлан: Х.Ганхуяг гишүүн ээ,

Наадах чинь НӨАТ-ын онолын асуудал болох гээд байна. Та өөрөө наад жуулчдын НӨАТ-ын буцаан олголтыг татварын буцаан олголт гэж андуураад байх шиг байна.

Жуулчдын **tax free** олон улсын ойлголт. Хэрэглэгч дотооддоо үүсээгүй учраас. Өөрөөр хэлбэл бараагаа худалдаж аваад 30 хоногийн дотор тэрийгээ бариад буцаад хилээр гарвал. Бүр хил дээр хардаг биз дээ.

Хэрэглэгч үүсэхгүй бол **tax free** гэдэг ийм ойлголтыг олон улсад одоо энэ аялал жуулчлалыг дэмжих гэж ийм ойлголтын бодлогоор явдаг.

Дотоодын НӨАТ, буцаан олголт гэдэг чинь шал өөр ойлголт. НӨАТ маань өөрөө аж ахуйн нэгжийнх бол албан татвар, эсвэл хувь хүний орлогын албан татвар шиг нэг удаагийн татвар биш.

Энэ өөрөө дамжуулан суутгадаг ийм гинжин татвар. Эцсийн хэрэглэгч өөрөө төлдөг.

Та нарыг одоо энд ингээд лобби явуулаад байгаа тэр дотоодын нислэгийн компаниуд чинь эцсийн хэрэглэгч нь тэр.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Б.Жавхлан гишүүн дахиад 1 минут нэмж хариулья.

Б.Жавхлан: Яах вэ энэ нэг онолын маргаан шиг юм болно.

Зүгээр ер нь ийм л зүйл байгаа юм. Татвартай холбоотой асуудал байвал Засгийн газраас санал авна л гэж байгаа юм. Тийм.

Засгийн газраас бүрэн санал авах ёстой. Тийм. Бид саналаа маргааш Засгийн газрын хуралдаанаар оруулаад хүргүүлье.

Ц.Цэрэнпунцаг: Дэгээрээ хэлэлцэхийг хэлэлцэж байх үед Засгийн газрын. Энэ дээр бид Засгаасаа саналыг сонсоно. Энэ бол анхны хэлэлцүүлэг.

Тэгэхээр одоо ингээд зарчмын зөрүүтэй саналаар ороод ирсэн учраас санал хураагаад явчихъя л гэж бодож байна.

Энэ дээр авах дэг алга. Анхны хэлэлцүүлэг. Хэлэлцэх эсэх дээр бол авна гэж байна. Дэгээрээ тийм байна.

Тэгэхээр одоо энэ ажлын хэсэг чинь ингээд харж байхад 4 гишүүн байна л даа. Ш.Адъяаа гишүүн байна. Энд алга

байна. Х.Булгантуяа гишүүн ороод ирж байна. Тийм ээ. М.Оюунчимэг гишүүн байна уу? ТДоржханд гишүүн бас байх шиг байна.

Тэгэхээр байна шүү дээ, энэ байна шүү дээ, Х.Ганхуяг гишүүн ээ. Ийм байхгүй юу. Одоо манай Байнгын хороон дээр ингээд дөрөв, таван Засгийн газрын гишүүн байж байна.

Тэгээд засаг дээрээ уг нь үүнийгээ нэг мөр болгоод ороод ирвэл бид энд ийм юм яриад сууж байх хэрэггүй байгаа юм.

Дэгээрээ хэлэлцэх эсэх дээр бол гарцаагүй Засгийн газрын саналыг сонсож авч үзэх ёстой юм байна.

Тэгэхээр энэ анхны хэлэлцүүлэг. Ажлын хэсэг нь зарчмын зөрүүтэй саналуудаа оруулаад ирсэн учраас.

Б.Бат-Эрдэнэ сайд аа,

Засаг дээрээ энэ хуультай холбоотой юмаа та чинь дуугараад, хэлээд, яриад санал бодлоо ярьдаг юм байгаа биз дээ.

Тэгээд ажлын хэсэг дээр энэ асуудлыг та нар ярьсангүй юу?

Тэгээд Байнгын хороон дээр ийм асуудал оруулж ирээд ажлын хэсэг дээрээ яриад, засагтайгаа яриад, засгаасаа нэг мөр болгоод орж ирээд явчих юмнууд ингээд задгай байгаад байх юм.

Ажлын хэсгийн 4 номерыг нээе.

Б.Бат-Эрдэнэ: Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ.

Засгийн газраас өргөн баригдсан хувилбар дээр ийм зүйл орон нутгийн нислэг болон нислэгтэй холбоотой НӨАТ-аас чөлөөлөх асуудал байхгүй.

Хэлэлцүүлгийн шатад гарч ирсэн зүйл. Дэд ажлын хэсэг дээр энэ асуудлуудыг ярьсан.

Өчигдөр Б.Жавхлан сайд ч орж ирж бас үүнтэй холбоо бүхий асуудлыг хөндсөн.

Бид tax free-тэй холбоо бүхий асуудлыг л өргөн барьсан.

Тэгэхээр хэлэлцүүлгийн шатад орж ирсэн санал л гэсэн үг.

Ц.Цэрэнпунцаг: Х.Ганхуяг гишүүн та тайлбар байна уу? Х.Ганхуяг гишүүн тайлбарлаадах.

Бид эхэндээ ярья гээд тэгж байсан шүү дээ. Байнгын хорооныхоо хуралдааны өмнө цөмөөрөө сонсьё, мэтгэлцээний хэлбэрээр энэ дээр байгаа асуудлуудаа ярья гээд түрүүн.

Х.Ганхуяг: Тийм. Б.Жавхлан сайд аа,

Улсын Их Хурлын гишүүд ээ, эрхэм гишүүд ээ,

Би хэлчихье л дээ. Энэ хууль нэн яаралтай горимоор орж ирсэн. Яах вэ, бид дунд нь хэлэлцүүлгүүд хийсэн. Хэлэлцүүлгийн шатанд ийм санал орж ирсэн.

Бид хугацаан дээр тулгасан юм ерөөсөө байхгүй шүү. Өнгөрсөн долоо хоногийн нэг дэх өдөр бид Засгийн газар луу санал авахаар бичгээ явуулсан. Өнгөрсөн долоо хоногийн тав дахь өдөр хүртэл хүлээсэн.

Тэгээд өчигдөр бид ажлын хэсгийн хурлаа хуралдуулаад энэ саналуудаа багцлаад багцлаад явсан байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Ер нь ийм байна.
Б.Жавхлан сайд аа,

Би ерөнхийдөө ингээд шийдчихье гэж бодлоо. Маргааш Засгийн газрын хуралдаанаараа та нар оруулаад үүнийгээ яриад ороод ир. Засгийн газраараа ороод ирэг. Засгийн газар дээрээ үүнийгээ та нар яриад.

Б.Бат-Эрдэнэ сайд аа, за юу.

Энэ асуудлаа яриад. Энэ дээр ямар асуудал үүсэж байна вэ гэдэг нь тодорхой байна шүү дээ. Хэлэлцэх хэсэг дээрээ үүнийгээ яриад үүнийгээ хоёр талдаа улаан шугамаа татаад орж ирэх байсан.

Дараа нь ажлын хэсэг дээр ингээд гишүүдээс санал гарч ирээд энэ асуудал ингээд хэлэлцэх эсэх дээр хөндөгдөлгүй анхны хэлэлцүүлэг дээр гараад ирж байгаа учраас бид нарт ийм хүндрэл гарч ирж байгаа учраас засаг дээрээ та нар маргааш Засгийн газар дээр яриад нэгмөсөн Засгийн газар дээр юу гэж шийдэлд хүрсэн гэдгээ шийдэлд хүрчхээд үүнийгээ ажлын хэсгээрээ оруулж ирээд тэгээд ярилцаад орж ирье.

Ингээд Б.Жавхлан гишүүний микрофоныг нээе.

Б.Жавхлан: Х.Ганхуяг гишүүн ээ,

Энд ийм байна шүү. Та хуулийн төслөө явуулаад санал авуулъя гэж бид нар луу бичиг ирүүлээгүй.

Та тоо, мэдээлэл хүссэн. Тоо, мэдээллийг бид явуулсан.

Маргааш Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхийн тулд та өнөөдөр бидэн рүү албан ёсоор яг энэ саналын томъёоллуудаа, хэлэлцсэн

асуудлуудаа хүргүүлээд, тэгээд бид маргааш саналаа хүргүүлье. Тийм.

Тэгэхгүй бол одоогоор ямар ч бид нарт яг яригдаж байгаа хуулийн төсөл нь бид нарт ирээгүй байгаа шүү.

Бид нараас асуусан гээд байгаа нь зөвхөн тоо, мэдээлэл хүссэн.

Ц.Цэрэнпунцаг: Ингэе ээ. Гишүүд ээ, Байнгын хороон дээрээ ийм асуудлууд хэлэлцээд сууж байх нь зохимжгүй байна.

Тийм учраас Б.Жавхлан гишүүн та горимын санал гаргачих. Хойшлуулъя гэдэг горимын санал гаргачих. Тэгээд саналаа хураагаад шийдчихье.

Х.Ганхуяг: 04 сарын 04-нд бичиг явсан. Засгийн газарт Д.Амарбаясгалан даргад.

Б.Жавхлан: Ингэе ээ. Татвартай холбоотой асуудал хэлэлцэх асуудал дотор орж ирж байгаа учраас дэгийн тухай хуулиараа Засгийн газар дээрээс бид албан ёсоор саналаа хүргүүлээд тэгээд хэлэлцэх нь зөв байх. Бид дэгийнхээ хуулийг хүндэтгэх хэрэгтэй.

Тийм учраас хэлэлцэх асуудлаас хойшлуулж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

Ц.Цэрэнпунцаг: Х.Ганхуяг гишүүн ээ,

Хэлэлцэх асуудлаа дараагийн долоо хоногт оруулчихъя даа. Энэ эхлээд горимын саналаа санал хураалт явуулчихъя.

Хангалттай л хэлж байна л даа. Та нар үүнийгээ цэгцэлчихгүй.

Эхлээд санал хураачихья. Тэгэх үү. Тусдаа ажлын хэсэг дээрээ уулзаад юм уу.

Б.Жавхлан гишүүн та ажлын хэсэг дээр нь ороод та нар саналаа ярилцаж болно биз дээ.

Х.Ганхуяг гишүүнд асуулт өгье.

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайд хоёр юм андуураад байна.

Би яам руу нь яг энэ татвартай нь холбоотой тоо, мэдээлэл авъя гэдгийг нь тусад нь явуулсан. Танай яам руу. Татвар луу тусад нь явуулсан. Яг Засгийн газар луу 2023 оны 04 сарын 04-нд Д.Амарбаясгалан дарга руу явуулсан байгаа. Тэгээд өнөөдөр чинь хэдэн юм. Өнөөдөр 4 сарын 11.

Тэгэхээр хоёр бичиг та хоёуланг нь сольж хутгаад байна. Тэгээд бид хүлээсэн. Тэр дээр нь яаралтай бид нарт хариу өгөөч ээ гэдэг мэдээлэл явуулсан. Өчигдрийг хүртэл юу ч ирээгүй. Энэ бол яаралтай гэж яачхаад, тэгээд хувийн хэвшлийнхэн нь ийм хүсэлт өгөхөөр.

Тэгэхээр дэг зөрчсөн юм уу, хууль зөрчсөн юм уу ерөөсөө юу ч байхгүй шүү. Тэгээд хоёр саналыг хооронд нь хутгаад байна.

Эсвэл тэр татвартай холбоотой хэсгийгээ дараа долоо хоногт хэлэлцэхээр хойшлуулаад, бусдыг нь эсвэл санал хураалтаар явчихвал яасан юм. Болохгүй юу?

Ц.Цэрэнпунцаг: С. Чинзориг сайд аа, та санал гаргаад яах уу?

Тэгвэл Ж.Бат-Эрдэнэ гишүүн та санал гаргах уу? Буцаачих. Буцаах горимын санал гаргаадах. Буцаачихья.

Түрүүн Б.Жавхлан гишүүний гаргасан горимын санал. Хойшлуулъя. Өнөөдрийн хэлэлцэх асуудлаас энэ асуудлыг авъя гэж байна. Тийм ээ.

Ингээд Б.Жавхлан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/ Гишүүд ээ, анхааралтай байгаарай.

Гишүүдийн 56.2 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Энэ асуудал хойшлогдсон учраас ингээд өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудал үүгээр өндөрлөж байна.

Ингээд Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан үүгээр өндөрлөж байгааг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Хуралдаан 26 минут үргэлжилж, 11 цаг 55 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД